



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

**Төрийн аудитын байгууллагын талаар
авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэг, Төрийн аудитын байгууллагын 2017 оны үйл ажиллагааны тайланг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай.

1/Засгийн газраас тухайн жилд хэрэгжүүлэх улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээ, хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэл болон байгуулах хөрөнгө оруулалтын гэрээнд аудит хийлгэж, дүгнэлт гаргуулдаг байх;

2/төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланд аудитын байгууллагаар аудит хийлгэсэн тохиолдолд төрийн аудитын байгууллагаар баталгаажуулдаг байх эсхүл төрийн аудитын байгууллагаар аудит хийлгэж, дүгнэлт гаргуулдаг байх зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид оруулах саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийн талаар Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулах.

2. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Ерөнхий аудитор /Д.Хүрэлбаатар/-т даалгасугай.

1/Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны хараат бус байдлыг хангах, гүйцэтгэх аудитын төлөвлөлтийг сайжруулах, хүний нөөцийг чадавхжуулах талаар хууль тогтоомжид оруулах саналаа боловсруулах;

2/гүйцэтгэж байгаа аудитын чанар, үр өгөөжийг дээшлүүлэн, аудитын дүнгээр гарсан акт, албан шаардлагын биелэлтийг тооцох зохицуулалтыг боловсронгуй болгож, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

3/Аудитын үр дүнгээр хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, түүний хэрэгжилтийн үр дүнг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулах;

4/төлөвлөгөөт жилд гүйцэтгэх аудитын сэдвийн саналыг боловсруулж өмнөх жилийн 1 дүгээр улиралд багтаан Улсын Монгол Их Хурлын Төсвийн байнгын хороонд ирүүлж, батлуулах.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Б.Чойжилсүрэн/-нд даалгасугай.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Б.ЧОЙЖИЛСҮРЭН